

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Орос, Хятад, Монгол Улсын харилцаан дахь Урианхайн хязгаарын асуудал /1921-1914/

БЕЛОВ Е.А.

Урианхайн асуудал Р.Кабо¹ болон В.И.Дулов² нарын номонд хөндөгдсөн. Эдгээр номонд Тагнын урианхайн газар нутаг Оросын ивээлд орсон түүхийг ерөнхийлөн харуулсан боловч 1912 онд хаант Орост цэргийн хүчээр нэтгэсэн гэдгийг онцлон дурьддаг.³ Гэвч энэ нь тийм биш байлаа. Тува оросын ивээлд орох үед тэнд оросын цэргийг оруулаагүй. 1912 онд хаант Оросын Засгийн газраас Усинскийн тойрогт Хилийн комиссараар /хэрэг дээрээ тувагийн асуудал хариуцсан/ томилсон А.Церериний мэдэлд хамгаалалтын 10 цэрэг байв. Бүр хожуу дэлхийн I дайны үед Урианхайн хязгаарт казакын суман оруулсан. Туваг Оросын ивгээлд оруулах асуудлыг улс төрийн аргаар, дипломат явууллага, Оросын зүгээс урианхай нар болон Хүрээн дэх монголын засгийн газарт шахалт үзүүлэх замаар шийдвэрлэсэн юм. БНХАУ-ын түүхч ид 1912-1914 оны үеийн Тагнын урианхай нар болон монголчуудын харилцааг зөвхөн дурьдан өнгөрдөг бөгөөд зарим үед алдаатай дүгнэсэн байдаг. Тухайбал Шанхай хотын Фуданий их сургуулийн түүхчид "хаант Оросын түрэмгийлэгчид" 1912 онд Тагна Урианхайн хязгаарыг Хятадаас хүчээр салган тусгаарлахын тулд Өргөөний тоглоомын "цэргүүдийг" тэнд оруулсан⁴ хэмээн бичжээ. Оросын архивын баримтууд хятадын түүхчдийн энэ дүгнэлтийг няцааж байна. Тэдгээр баримтууд хаант оросын дипломат бодлого Хүрээг урианхайн хэрэг явдалд оролцуулахгүйн тулд бүхнийг хийж байсныг гэрчилж байна. Үүний улмаас Петербург, Хүрээний хооронд санал ноцтой зөрөлдөж байв.

Урианхайн хязгаар бол зүүн болон хойд талаасаа Саяаны нуруугаар, өмнө талаасаа Тагны нуруугаар халхлагдсан уул-тал хосолсон хотгорт оршино. Баруунаасаа зүүн тийш 1000 гаруй км, хойноосоо урагш 100-350 км үргэлжилдэг. XX зууны эхэнд 150 мянга орчим хав.дөр.км дэвсгэртэй байв. Оросууд уугуул оршин суугчдыг-соёдууд, хятадууд-урианхайчууд /Тагна-урианхай/, харин тэд өөрсдийгөө тува-соён гэж нэрлэж байв.⁵

1916 онд оросын элч Туманц Хэмчиг голоор нүүдэллэж байсан монголын алтанхан Хун тайжаас Оросын харъяанд орохоор өргөсөн тангарагийг хүлээн авчээ. 1636 онд Увс нуур болон Тэс гол хавиар нутаглаж байгаад шинэ Цин гүрний бүрэлдхүүнд орсон. 1727 оны орос-хятадын Буурын болон Хиагтын гэрээнүүдээр Орос-Хятадын хилийн Урианхайн хязгаар дахь

хэсгийг тогтоосон. Уг хил нь Аргунь голоос Шавийн даваа хүртэл Саяаны нуруугаар өнгөрдөг. Шавийн даваанаас баруун урагш Чавчаал даваа хүртэл хилийн тэмдэгтүүдийг орос, хятадын хилийн комиссарууд 1869 онд босгосон /Хиагтаас Шавийн даваа хүртэл нийт 24 тэмдэгт/. Бээжин дахь элчин И.Я.Коростовец Енисейн губерн болон Урианхайн хязгаар дахь орос хятадын хилийн асуудлыг тусгайлан судлаад, 1909 оны 4-р сарын 4-нд Оросын ГЯЯ-ны сайд А.П.Извольскийн явуулсан нууц мэдээлэлдээ: "Хиагт болон Шавийн давааны хоорондох хилийг тогтоосон Буурын гэрээний заалтууд дараачийн гэрээнүүдээр өөрчлөгдөлгүй өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна" гэж бичжээ.⁶ Оросын сайд нарын зөвлөл 1911 оны 11-р сарын 21-ны өдрийн хуралдаанаа урианхайн асуудалд зориулан хийсэн бөгөөд урианхай нар XVIII зууны дунд үеэс "хэрэг дээрээ Богд хааны харьяанд орж, хятадын засаг захиргааны байгуулалттай болсон" хэмээн үзсэн юм.⁷

1755 оноос Урианхайн хязгаарыг Улиастайн жанжинд харъяалуулан, түүний захиргаанд хязгаарын амбан болон Бэйс, Да/Хэмчиг/, Ойнар, Салчиг, Тож гэсэн 5 хошууны ноёд орсон. Засаг захиргааны хувьд Урианхай нь Монголтой адил байв. XX зууны эхээр нийт 47 хошууны 26 нь улиастайн жанжинд, 13 нь Сайн ноён хан аймгийн, 5 нь Засагт хан аймгийн ноёнд, 3 нь Хүрээний хутагтад харъяалагдаж байлаа. Тэд харьяандаа байгаа урианхайн хязгаарын хошуу сумдаас мал, ангийн үсээр алба татварлан авч байв. Урианхай нарын ихэнх нь мал аж ахуй, ан гөрөө хөөж, цөөн тооны ардууд Хэмчигийн голоор газартай малаа эрхэлж байв. Тэд ламын шашин шүтэж, монгол бичиг хэрэглэж байв. Уугуул оршин суугчдын тоо тун цөөн 45-50 мянга, тэд гол төлөв Хэмчиг голын сав-Да болон Бэйс хошуунд төвлөрөн суудаг байв.⁹

XIX зууны 60-аад оноос эхлэн оросууд Урианхайн хязгаарт суурьшиж эхэлсэн. Анхны шилжин суурьшигчид нь нутгийн засаг захиргаа болон үнэн алдартны шашны сүмд хавчигдан хөөгдсөн сибирийн хуучин номтон шимээсгүүд байв. Гэвч хожим нь Оросын үйлдвэр худалдааныхан, тариачид, малчид ирцгээсэн юм. 1910 онд Урианхайн хязгаар дахь орос хүн амын тоо 5 орчим мянгад хүрч, тэнд оросын худалдааны 80 фирм, сургууль, үнэн алдартны сүм бий болжээ.¹⁰ 1912 онд тус нутагт оросын үйлдвэрийн эздийн нээсэн 73 алтны орд ажиллаж байв. 1879 оноос 1908 он хүртэл тэд эндээс 705 пүү /1 пүү-16.3 кг/ алт олборложээ.¹¹

Сибирийн засаг захиргаа, хаант засгийн газар ч гэсэн Урианхайн хязгаар руу очиж суурьших орос иргэдийн шилжилт хөдөлгөөнийг нүд анин өнгөрөөж байв. Тэд эхний үед хятадын засаг захиргааны дургүйцлээс эмээн ихэд болгоомжилж байлаа. Баруун Монгол болон Урианхайн хязгаарыг судалсан оросын нэрт эрдэмтэн Г.Е.Грум Гржимайло энэ талаар бичихдээ: "Урианхайн газар нутгийг тариачид колоничилсон тухайд Петербург улс төрийн байдлаас хамааран зарим үед орос иргэдийг бөөн бөөнөөр Усинскийн

хязгаарт буцааж байсан бол зарим үед Саяаны чанадыг зорьсон тэдний тогтоох аргагүй шилжилт хөдөлгөөнийг нүд анин өнгөрүүлж байв” гэжээ.¹²

Орос иргэд шилжин суурьших үйл явц XX зууны эхний 10 жилд улам эрчээ авав. 1910 оны байдлаар орос тариачид Урианхайд 3 мянга гаруй десятин газар буюу 10 жилийн өмнөхөөс 3 дахин их газар хагалбарласан байв.¹³ Монгол, Урианхай дахь хятадын засгийн газрын үйл ажиллагаа идэвхижиж ирсний улмаас Хаант оросын засгийн газар тэнд явуулах бодлогоо ч мөн хүчтэй болгов.

XIX зууны сүүлчээр Урианхайн хязгаарг Чин гүрний засгийн газар хятад худалдаачдыг нэвтрүүлэхийг хориглодог байсны улмаас маш сул байв. Энэ зорилгоор Тагнын нурууны урьд биеэр, өөрөөр хэлбэл Монгол-Урианхайн хилийн зааг дээр хятадын харуулуудыг суулгасан юм.¹⁴ Монголыг колоничлох бодлогыг хөхүүлэн дэмжих зорилгоор 1903 онд Улиастайн жанжин хятадын худалдаачдад Урианхайн хязгаарт чөлөөтэй нэвтрэхийг зөвшөөрчээ.¹⁵ Энэ үеэс Хятадын худалдаа түргэн хөгжин 1910 онд Урианхайд 30 салбар бүхий Хятадын 10 том пүүс ажиллаж байлаа.¹⁶ Тус нутагт оросын эсрэг сурталчилгаа өрнөж, урианхайчууд оросуудын хооронд маргаан гарах нь нэмэгдэж ирэв. Улиастай дахь Оросын консулын үүрэг гүйцэтгэгч В.Долбежев 1909 оны 1-р сард Орсын ГЯЯ-нд явуулсан мэдээлэлдээ 1900 оноос уугуул хүн ам шилжин суурьшигчдад "таагүй" хандах болсон, мөн түүнчлэн Усинскийн Хилийн захиргааны түшмэд болон орос худалдаачдын өөрсдийн хувийн уян хатан бус зан чанарын улмаас орос, урианхай нарын харилцаа "улам бүр хурцадсаар байна" гэж мэдээлжээ.¹⁷ 1908 оны сүүлчээр Да хошууны ноён Хайдав Хэмчиг голын хөндийд сууж байсан бүх орос иргэдэд Урианхайн хязгаараас гарахыг санал болгов. Тэр мөн Усинскийн тойрогтой хил залгаа нутагт харуул хамгаалалт тавьж байв. Энэ тойргийн хилийн албаны дарга А.Х.Чакиров эрхүүгийн амбан захирагч Селивановт хандан оросоос шилжин суурьшигчдад туслахыг хүсчээ. Селиванов 1909 оны 1-р сард Усинскийн тойрог руу хурандаа В. Поповоор ахлуулсан 15 казакуудаас бүрдсэн цэргийн отряд илгээжээ. Тэд хил дээрх урианхайн харуулуудыг хөөн явуулж, В.Попов Хайдавт оросуудыг хөндөхгүй байхыг анхааруулжээ.¹⁸ харин Хайдав орос оршин суугчдын эсрэг өөрийн үйл ажиллагаагаа Улиастайн жанжин Куй Фаны зааврын дагуу үйлдсэн хэмээжээ. Иймээс В.Долбежев Ку Фанд Хайдавын "таагүй үйл ажиллагааг" хянан тохинуулах, түүний орос иргэдийн талаар гаргасан захирамжийг хүчингүй болгуулахын тулд Хэмчиг рүү манж түшмэл илгээхийг хүсчээ. Куй Фан Оросуудыг шахахгүй байхыг Хайдавт сануулахаар түшмэл Зи Шунийг томилон явуулав.¹⁹

Урианхайн хязгаар руу цувах орос иргэдийн тоо нэмэгдэж, урианхай нар оросуудын хоорондын харилцаа хурцдан Хятадтай зөрчилдөх болсон нь хаант засгийн газарт Урианхайн хязгаарын статусын асуудал гарч ирэхэд хүргэв. Урианхайд аж ахуй эрхэлж байсан Оросын зарим үйлдвэрийн эзэд /

жишээлбэл, И.Г.Сафьянов/, 1909 онд Эрхүү мужийн захирагч М.С.Князевийн томилсон Жанжин штабын хурандаа В.Л.Попов²⁰ болон зарим улс төрийн зүтгэлтнүүд урианхайн газар нутгийг Орост нэгтгэх санал дэвшүүлж байв.

1907 онд судалгааны ангийн хамт хүрч ирсэн зам харилцааны инженер В.Родевич Засгийн газартаа бэлтгэж өгсөн илтгэлдээ: "Урианхай бол үнэхээр орос-хятадын зааг дахь хамгийн бага эсэргүүцэлтэй цэг: үүний цаана бүхэл бүтэн баян тансаг муж байна. Хэрэв Хятад манай Амар мөрний хавиар даралт шахалт үзүүлж эхэлбэл түүний хариуд хамгийн бага хүч зарж амжилт олох нутаг бол Урианхайн хязгаар юм"²¹ хэмээн бичсэн байдаг. 1908 оны 1 р сарын 24-нд Николай II Родевичийн илтгэл дээр: "Сэтгэл нэн ханамжтай уншлаа. Енисейн эх болон Урианхайн хязгаарыг судалж эхэлсэн ажлыг үргэлжлүүлэх шаардлагатайг олж мэдлээ. Энэ нутаг ирээдүйд Орост маш ашиг тус өгч болох юм"²² гэж тэмдэглэхийг тушаажээ.

Сайд нарын зөвлөл ерөнхийдөө энэ хязгаар нутгийг бүхэлд нь судлахад бэлтгэх арга хэмжээ авах, юуны урьд хилийн асуудлыг тодруулах шинжилгээний тусгай анги явуулахаар шийдвэрлэсэн байна. 1910 онд В.Л.Поповоор ахлуулсан шинжилгээний тийм ангийг Урианхайн хязгаар руу илгээсэн бөгөөд түүний бүрэлдэхүүнд Цавчаал дахь хилийн баганыг шатаасан түрүүч Августус байсан юм.²³ Энэ тухай Улиастайн жанжин мэдээд Томскийн захирагчид хандан хилийн тэмдэгтүүдийг хамтран шалгахыг санал болгосон ажээ. Энэ асуудлыг хэлэлцэхэд П.А.Столыпин ч бас оролцон, 1910 оны 5-р сарын 28-нд Томскийн захирагчид цахилгаан явуулжээ. Уг цахилгаанд дурьдахдаа "улсын хилийн Томск мужийн хэсгийг цаашид шалгахдаа манай баруун талын болон Байгалийн чанадын хилийн жишээгээр хэлэлцээний материалыг урьдчилан судалсны дараа байр зүйчдээс бүрдсэн олон улсын комиссын туслалцаатайгаар шалгах хэрэгтэй хэмээн үзэж байгааг минь Бээжинд суугаа манай Элчин ба Улиастайд суугаа консулд мэдэгдэхийг даалгасныг Эрхүүгийн захирагчид дамжуулна уу. Үүнд шаардлагатай хөрөнгө мөнгийг зөвхөн хуулийн дагуу гаргаж болох тул Урианхайн хилийг нэн даруй шалгах асуудал ирэх жилийн зун болтол хойшлогдож байна" гэжээ.²⁴

Эндээс харахад П.А.Столыпин олон улсын шинжээчдийн комисс байгуулах замаар Урианхайн хязгаар-Оросын хилийг хамтран шалгах ажлыг хойшлуулахыг хүсч байжээ.

Улиастайд сууж байсан Оросын консул В.Ф.Люба манж жанжинтай Чавчаалд болсон хэрэг явдлын талаар хэлэлцээ хийсэн боловч юу ч тохиролцож чадаагүй. Энэ асуудлыг Бээжинд И.Я.Коростовец Хятадын ГЯЯ-тай хийж байсан хэлэлцээрт шилжүүлжээ. И.Я.Коростовец 1909 онд Урианхайн хязгаар бол Хятадын нутаг дэвсгэр тул орос-хятадын харилцаанд хурцадмал байдал гаргахгүйн тул түүний бодлоор "уг хязгаар нутгийг оросууд колоничлохыг зогсоох" нь зохистой хэмээн үзэж байлаа.²⁵ Гэтэл 1910 онд

түүний энэ үзэл бодол өөрчлөгдөн "Орос урианхайн газар нутгийг эзэмших" тухай В.Л.Поповын үзлийг дэмжих болжээ.²⁶ 1910 оны 3 ба 4-р сард И.Я.Коростовец Хятадын ГЯЯ-ны сайд Цинд Урианхайн хязгаар бол "маргаантай нутаг" гэж мэдэгдэв.²⁷ Тэрбээр ГЯЯ-ны сайд С.Д.Сазановт "ядаж Урианхайн хэсэг нутгийг ч гэсэн олж авах"-ын тулд тодорхой арга хэмжээ авахыг зөвлөсөн ажээ. И.Я.Коростовецоос ирүүлсэн энэхүү мэдээлэл дээр Николай II "зөвшөөрч байна" гэсэн тэмдэглэгээ хийжээ.²⁸

Цин ноён болон Улиастайн жанжин Куй Фан нар Чавчаалд хилийн тэмдэгтийг шатаасан хэргийг мөрдөн шалгах орос-хятадын хамтарсан комисс байгуулахыг шаардсаар байлаа. Харин Петербуртг үүнийг хүсэхгүй байв. 1911 оны 4-р сарын 12-нд С.Д.Сазановын туслах /орлогч/ А.А.Нератов И.Я.Коростовец руу явуулсан цахилгаандаа: "Сайд нарын зөвлөлийн дарга мөн түүнчлэн Цэргийн болон Сангийн яамны сайд нарын саналын нэг адил Августус Чавчаал даваан дээр хилийн багана шатаасан асуудлыг мөрдөн шалгавал одоо мөрдөж буй (Хиагтын) гэрээний хоёрдугаар зүйл ба Чугучакийн протоколоор тогтоосон дээр дурьдсан хилийн баганыг сэргээн бататгахад хүргэнэ хэмээн болгоомжилж байна.^{28a} Эдгээр баримт бичгүүдээр Урианхайд тогтоосон хилийн асуудлыг манай талаас өдөөх боломж гаргахын тулд дурьдсан хилийн баганыг шалгах явдлаас ямар нэг шалтгаар зайлсхийх"²⁹ нь зүйтэй байна гэжээ.

Я.Коростовец Хятадын ГЯЯ-нд чавчаалын хэрэг явдлыг "урианхайн хилийг бодит байдал дээр шалгах хүртэл"³⁰ хэлэлцэхийг хүсэхгүй байгаагаа мэдэгджээ. Гэвч хятадууд хэлэлцээрийг үргэлжлүүлэхийг шаардсаар байв.

Урианхайн хязгаарт Оросын хаант засгаас идэвхитэй бодлого явуулж буй тухай мэдээлэл хятадын олон нийтэд хүрч байв. Бээжингийн нэг сонин энэ тухай: Урианхайн хязгаар бол "эрт дээр үеэс Монголын бүрэлдхүүнд байсан бөгөөд монголын бусад нутгийн хамт Чин гүрний харъяанд орсон тул тийш нь цэргийн тусгай анги илгээн Улиастайн жанжинд шууд захирагдаж байлаа.Эдүгээ улсын хилийг дахин хянан үзэх асуудлыг оросууд гаргаж ирээд, ямар ч үндэслэлгүйгээр хилийн шугам Саяаны нуруугаар бус Тагна уулаар байх ёстой хэмээн шаардах боллоо. Юунд ч үндэслээгүй Оросын энэ тулгалт нь ямар ч байсан Урианхайн хязгаарыг эзлэн авах гэсэн оросуудын хүслийг илтгэж байна".³¹

И.Я.Коростовец Хятадын ГЯЯ-тай чавчаалын хэрэг явдлын талаар хийсэн хэлэлцээ маш удааширсан. Оросын элч Урианхайн хязгаарын хил маргаантай гэдгээр шалтаглан "Чавчаалын даваан дээр хилийн багана устгасан тохиолдлын чанартай зүйлийг"³² авч хэлэлцэхийг хүсэхгүй байна гэжээ. Цинь үүнийг эсэргүүцэн хил маргаантай гэдгийг няцааж Чавчаал дахь баганыг сэргээхийг шаардсан.³³ 9-р сарын 19-нд И.Я.Коростовец А.А.Нератовт мэдээлэхдээ: "Цинь Чавчаалд багана босгохоор заасан 1869 оны протоколыг дурьдан тэнд хилийн багана сэргээхийг шаардаж байна. Хятадууд Урианхайн бусад хэсгийн хилийн асуудал ярихаас зайлсхийж, нөгөө

талаас тэдэнд ашигтай байгаа Шавийн давааны хилийн төгсгөлийн тэмдэгтийг хэвээр хадгалахыг чармайж байна” хэмээжээ.³⁴

Эрхүүгийн захирагч М.С.Князев Сайд нарын зөвлөлд захиа илгээн хятадын засгийн газар Урианхайруу цэрэг илгээж болзошгүй бөгөөд ингэвэл "Урианхайн хязгаарын харъяаллын асуудал манайд ашиггүйгээр шийдвэрлэгдэнэ гэсэн үг" хэмээн болгоомжлуулжээ.³⁵ Тэрбээр засгийн газартаа энэ талаар "илүү шийдэмгий арга хэмжээ" авахыг санал болгосон байна. И.Я.Коростовец мөн Урианхайн хязгаарыг хятадууд эзлэн авахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй бөгөөд үүний тулд "маргаантай урианхайн нутагтай" залгаа орших оросын мужуудад хааны цэргийн хүчийг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.³⁶

1911 оны 11-р сарын 21-нд Сайд нарын зөвлөлийн хурлыг В.Н.Коковцев удирдан явуулж Урианхайн асуудлыг тусгайлан хэлэлцэв. Хурлын гол итгэлийг А.А.Нератов тавив. Хуралдаанаар Урианхайн хязгаарыг Оросын эзэнт улсын харъяа хэмээн үзэж болох уу гэдэг асуудал хэлэлцжээ. Энэ талаар А.А.Нератов хэлэхдээ, "Урианхайн хязгаарыг Хятад манайд өгөх буулт хийж байсан буюу Хятад-Оросын хил тогтоох үед түүнийг манай хилд оруулж байсан нотлох баримт байхгүй" гэжээ. Тэр цааш нь ГЯЯ-ны Москвагийн гол архивт орос-хятадын хилийн Урианхайн хэсгийг тогтоосон тухай баримтуудад хайлт хийж үзэхэд "харамсалтай нь гүн Рагузинский Урианхайн хязгаарыг манайд шилжүүлэх талаар буулт хийлгэж чадсан гэдгийг нотлох баримт олдоогүй.³⁷ Харин ч дээр дурьдсан архивын өнөөг хүртэлх баримт, материалууд 1772 оны 8-р сарын 20-ны Буурын гэрээгээр манай улсын хилийг хилийн комиссар Колычев Саяаны нуруугаар тогтоосон гэдгийг нотолсон огт өөр дүгнэлтэнд хүргэж байна. Иймээс бидэнд Урианхайд өнгөлзөж буй хятадуудын эсрэг сөргүүлэн тавих гэрээгээр бататгасан маргаангүй баримт нотолгоо алга"³⁸ хэмээн ярьжээ. Эхэлж буй Цагаагчин гахай жилийн хувьсгалтай холбогдуулан А.А. Нератов урианхайн асуудлын талаар дор дурьдсан зүйлийг мэдэгдсэн байна. Үүнд: Хятадад гарсан хувьсгалыг /гадаад гүрнүүд Е.Б/ түүнтэй тооцоо бодох болон газар нутгийг булаан эзлэхэд ичгүүр сонжуургүй ашиглахыг эрмэлзэж байгаа нь манайхыг урианхайн асуудалд илүү идэвхитэй үйл ажиллагаанд түлхэж байна" гэв.³⁹ Сайд нарын зөвлөл Орост "Урианхайн хязгаарыг эзэмших хууль ёсны үндэслэл байхгүйг тэмдэглэж байв.⁴⁰

Сайд нарын зөвлөл Урианхайн хязгаарыг орос иргэдээр эзэмшүүлэх явдлыг эрчимжүүлэхээр шийдвэрлэжээ. Энэ нутагт 400 мянган хүн суурьшуулж, хүн бүрд 50 десятин газар оногдоно хэмээн үзэж байлаа.⁴¹ "Урианхайн хязгаарт ихээхэн орос суурин байгуулбал бид тэнд оршин суугаа оросын харъяатуудаа хамгаалах бат түшиг тулгууртай болж улмаар өөрийн ивээлдээ авах чиглэл рүү бодлогоо хандуулах, алс ирээдүйд Урианхайн хязгаарыг шууд нэгтгэн авч болох юм" хэмээн Сайд нарын зөвлөлийн шийдвэрт өгүүлжээ.⁴² Николай II энэ шийдвэрийг зөвшөөрчээ.⁴³

Ийнхүү засгийн газраас боловсруулсан программ нь Урианхайн хязгаар дахь оросын нөлөөг бэхжүүлж, цаашдаа тайван замаар нэгтгэхэд чиглэж байлаа.

Бээжинд сууж байсан хэргийг түр хамаарагч М.С.Шекиний мэдүүлснээр 1911 оны 12-р сард Монгол улс тусгаар тогтнолоо зарласны дараа Хүрээний засгийн газар Өвөр Монгол, Барга, Ховдын тойрогт их анхаарал тавьж, "Урианхайн хязгаарыг бага сонирхож байлаа". Хаант засгийн дипломат С.Д.Сазановт "хамгийн тааламжтай үеийг ашиглан" оросын харуулуудыг Тагнын нуруу дагуулан байрлуулах, өөрөөр хэлбэл хэрэг дээрээ Урианхайн хязгаарыг булаан эзлэхийг зөвлөжээ. С.Д.Сазанов түүний саналыг зөвшөөрөөгүй бөгөөд М.С.Шекинаас ирүүлсэн яаралтай цахилгааныг Николай хаанд илгээхдээ Орост Урианхайн хязгаарыг авах хууль ёсны эрх байхгүй тул Саяаны нуруу ба Тагны нурууны хооронд орших нутгийг эзлэхэд зөвхөн тэнд байгаа манай эрх ашгийн үүднээс хандаж болох юм. Гэвч тэнд явагдаж буй үйл явдал Урианхайн хязгаарт сууж байгаа орос иргэдийг цэргийн хүчээр хамгаалах болон Сайд нарын зөвлөлийн боловсруулсан программаас татгалзахад хүргэж байгаа эсэх нь надад тодорхойгүй байна"⁴⁵

С.Д.Сазановын энэ байр суурь хаанд нөлөөлөөгүй тул түүний ирүүлсэн бичиг дээр: "Би үүний эсрэг саналтай байна. Бээжин дэх хэргийг түр хамаарагчийн саналыг бүрэн дэмжиж байна. Урианхайн хязгаарын асуудлыг хэлэлцсэнээс хойш 3 сар гаруйн хугацаа өнгөрч, Хятадад томоохон өөрчлөлт гарсан учир бид энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд илүү идэвхитэй ажиллах хэрэгтэй байна. Эс бөгөөс бид хятадын хилийн дагуу ямар ч амжилт олохгүй" хэмээн тэмдэглэжээ.⁴⁶

Мөн чанартаа цэргийн хүчээр Урианхайн хязгаарыг нэгтгэх гэсэн хааны заалтыг засгийн газар биелүүлээгүй. Бидний төсөөлснөөр С.Д.Сазановт хааны үгийг дагахгүй байх ноцтой үндэслэл байсан.

Монголын асуудлаар Хятадтай хийж байсан хэлэлцээр хүнд нөхцөлд явагдаж байв. Хятадын засгийн газар Монголыг Хятадаас салгахад нэн эсэргүүцэж, Оросыг Гадаад Монголын статусын тухай хэлэлцээрт зуучлахыг үл зөвшөөрөн түүнийг өөрийн харъяанд буцаан авахыг найдсаар байлаа. Хаант засгийн газар Халхын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх асуудал дээр ч ямар нэг буулт хийхгүй байсан тул Хүрээний засгийн газар 1912 оны хавар, зун Бээжин рүү хэлбийх болсон. Урианхайг Орос нэгтгэн авбал Хүрээ маш их эсэргүүцэхээр байв.

Монголын тусгаар тогтнолыг зарласан нь урианхай нарт маш их нөлөө үзүүлсэн билээ. 1912 оны 2-р сард тэд өөрийн нутгаас хятадын бүх худалдаачдыг үлдэн хөөжээ. Улиастай дахь Оросын Консул А.Вальтер 1912 оны 2-р сард Петербург рүү мэдээлэхдээ: "Урианхай дахь хятадуудын орон байр орвонгоороо дээрэм тонуулд өртөн, тэдний өмч хөрөнгийн нэг хэсгийг урианхай нар зөөж, үлдэх хэсгийг галдан шатаасан. Хятадын худалдаачдын мал сүргийг нутгийнхан туун авч явсан. Олон тосгон сууринг галдан сүйтгэв.

Хятадууд амь зулбан зугадсаны ихэнх нь орох орон, өмөг түшиг эрэн Улиастай руу одсон юм. Тэдэнд учирсан хохирол хэдэн зуун лан мөнгөөр хэмжигдэнэ гэжээ"⁴⁷

Хятадын засаглалаас салсны дараа урианхай нар ивээл тусламж Оросоос бус Хүрээнээс эрэлхийлэх болсон. 1912 оны 4-р сарын эхээр Салчиг хошууны ноён Балжинням болон Тож хошууны ноён Тогмид нар Хүрээнд, мөн түүнчлэн Засагтхан аймгийн нөлөө бүхий том лам Жалханз хутагтад нэг зэрэг хандан тус аймгийн бүрэлдхүүнд Богд гэгээний ивээлд авахыг хүсцгээжээ.⁴⁸ Тэдгээр хошуу ноёд бичихдээ: "Богд гэгээний ивээлд ороход маань туслахыг хичээнгүйлэн хүсье. Жалханз гэгээн Танаа бидний энэ шийдвэр эцсийнх бөгөөд хойшид түүнээс няцахгүй гэдгээ андгайлъя.

Тэнгэр, газар, ариун бүхнээ барьж тангарлая".⁴⁹ Тэд Орост талтай хандаж хоёр хошууг Халхад нэгтгэхийн эсрэг байгаа амбан ноён Гомбодоржийн⁵⁰ талаар гомдол мэдүүлээд монгол цэрэг илгээхийг гуйжээ.

Хүрээний засгийн газрын Гадаад явдлын яамнаас Ховдын захирагч Гончигдамбад Салчин болон Тож хошууд руу "тэндхийн хүн амыг түвшигтгэн, амбан Гомбодоржийн зүгээс бэлдэж буй халдлагаас хамгаалахын тулд монгол түшмэдийг цэргийн хамт томилон илгээхийг даалгасан байна"⁵¹ Улиастай дахь оросын консулын үүрэг гүйцэтгэгч А.Хионин Петербург руу ихэд цухалдангуй мэдээлэхдээ: "Хутагтын засгийн газар асуудлын мөн чанарыг судлан үзэлгүй зөвхөн урианхай нарын өргөдөл хүсэлтээр хязгаарлан тэдний газар нутгийг Монголд нэгтгэх нь хамгийн тохиромжтой үе хэмээн үзэж байна. Энэ зорилгоор тийшээ монгол ноёдыг цэргийн хамт хязгаар нутагт амгалан тайван байдал тогтоох, хүн амыг Ойнарын амбан ноён Гомбодоржийн халдлагаас хамгаалах нэрийдлээр томилон илгээх тушаал гаргаад байна. Салчиг болон Тож хошуудыг түвшитгэсний дараа /хүрээний/ яамны газрын хэлж байгаагаар урианхайн нутаг дэвсгэрийг хуульчлан авах ажээ".⁵²

Хүнд байдалд орсон Гончигдамба ноён А.Хиониноос зөвлөгөө өгөхийг хүсэхэд, тэрбээр "монголын засгийн элч төлөөлөгчийг цэргийн хамт Халхын бүрэлдхүүнд ороогүй хязгаар нутаг руу илгээх нь үл ойлголцох байдал бий болгон, монголчуудад таагүй уршиг тарьж болзошгүй тул зүй зохистой зүйл хэмээн үзэхгүй байна" гэж Хүрээ рүү мэдээлэхийг санал болгожээ. Тэгээд оросын консулын ажилтан улиастайн ноёнд шуудхан Орос улс "Урианхайн хязгаарт маргашгүй эрхтэй" хэмээн хэлсэн байна.⁵³

А.Хиониноос ийм сэрэмжлүүлэг авсаны дараа улиастайн засаг захиргаа Урианхай руу цэрэг илгээж зүрхлээгүй. Гэхдээ энэ нөхцөл байдал Хүрээ, Петербургийн хооронд урианхайн асуудлаар ноцтой зөрчил байгааг харуулсан. Энэ асуудлын талаарх Бээжингийн байр суурь 1912 оны 5-р сард хятадын парламентаас гаргасан тунхаглалд тодорхой тусгагдсан. Уг баримт бичигт Урианхайн хязгаар нь тухайн үед Хятадын БНУ-ын бүрэн мэдэлд буй баруун Монголд харъяалагдана гэж заасан байв.⁵⁴

1912 оны 10-р сарын эхээр Хүрээнд ирсэн И.Я.Коростовец Петербург рүү явуулсан мэдээлэлдээ: Тагна-Урианхайн хошуудаас шашин, оюун санааны нэг удирдлагатай Халхын ивээлд багтаан авахыг хүссэн хүсэлтүүд байнга ирж байна⁵⁵ гэж дурьдсан ажээ. Мөн Да, Бэйс хошууд Халхын хутагтын ивээлд орох хүсэлтээ илэрхийлсэн.⁵⁶ С.Д.Сазанов И.Я.Коростовецоос Урианхайн хязгаар хутагтын эзэмшил биш гэдгийг монголчуудад мэдэгдэн тодорхой, хатуу байр суурьтай байхыг хүсчээ.⁵⁷

1912 оны зун урианхай нар хятадуудаас Ховдыг хамгаалахаар 300 хүнтэй сайн дурын цэрэг эмхэлсэн билээ. Дайнд мордохын өмнө тэд найр наадам хийн, мөргөл үйлдэж эр зоригтой тулалдахаа тангараглаж байлаа.⁵⁸ Энэ бүхэн урианхай нар хятадуудын эсрэг тэмцэлд монголчуудтай хамт байхыг хүсч байсныг харуулж байна. Хаант засгийн газар Урианхайд бий болсон нөхцөл байдалд санаа зовж байв. 1912 оны зун Урианхайн байдлыг хянаж байх консулын эрх бүхий Хилийн Комиссарын албан тушаал бий болгохоор төлөвлөж байлаа. Мөн оны 6-р сард ГЯЯ-наас "Урианхайн комиссарт зориулсан зааварчлагаа" бэлтгэжээ. Түүнд өгүүлэхдээ: "Эзэн хааны засгийн газар Урианхайн хязгаарын цаашдын хувь заяаг хараахан эцэслэн шийдвэрлээгүй байна. Энэ нь алс дорнод дахь манай бодлогын улс төрийн томоохон асуудлуудын урьдчилсан үр дүнтэй холбоотой юм" гэжээ.⁵⁹ Хилийн комиссар урианхай нарт "хятад болон монголчуудаас үл хамаарах өөрөө удирдах ёс баримталбаас та бүхэн эрх ашгаа хамгаалах, үндэсний эв нэгдлээ хадгалахад дээр" гэдгийг тайлбарлан таниулах хэрэгтэй. Тэрбээр бас "манай худалдаа, колончилалыг дэмжих замаар оросын нөлөөг тус нутагт бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх" ажээ.⁶⁰ Комиссар өөрийн мэдэлд хамгаалалтын цэрэгтэй байх ажээ.⁶¹ ГХЯ болон Дотоод яаманд олон удаа хэлэлцэн зөвлөлдсөний дараа Усинский тойргийн Хилийн асуудал эрхэлсэн түшмэлийн албан тушаал⁶² батлагдав. Уг албанд Эрхүүгийн захирагчийн дэргэдэх тусгай үүрэг бүхий түшмэл А.Церерин томилогдсон. 1913 оны 4-р сарын эхээр А.Церерин Урианхайд ирж нутгийн байдалтай танилцсаны дараа "урианхайчууд /ганцхан Амбан ноёноос бусад/ шашин нэгт монголтой нийлэх гэсэн нийтлэг эрмэлзэлтэй байна" гэж тэмдэглэсэн байдаг.⁶³ М.С.Князевийн мэдүүлснээр А.Церерин "анхны алхам" болгож Да, Бэйс хошуудаас "монголын ухуулагч түшмэдийг хөөсөн байна"⁶⁴ Салчиг болон Тож хошуудын хувьд Хүрээний Хутагт тэдний ноёдод гүнгийн зэрэг, хошуу тамга олгон өөртөө хүчтэй татсан байв.⁶⁵

Урианхайн хязгаарын захирагч амбан ноён Гомбодорж 1912 онд Салчиг, Тож хошуудыг Халхтай нэгдэхийг эсэргүүцэж байсан бол 1913 онд өөрийн "харъяа хошуудыг Халхын ивээлд багтаан авахыг" Хүрээнээс хүссэн байна.⁶⁶ 1913 оны хавар тэр энэ зорилгоор Улиастай, Ховд явжээ. Амбан ноён Ховдод Оросын Консул В.Любатай уулзан ярилцахдаа "урианхайн ард түмэн тусгаар тогтносон Монгол улстай нэгдмэл хүсэл эрмэлзэлтэй байна" гэв.⁶⁷ 1913 оны 5-р сарын сүүлчээр Хүрээн дэх хаант засгийн дипломат төлөөлөгч

И.Я.Коростовец Петербург руу "Гомбодорж Халх руу хандсан хэвээр байгаа төдийгүй өөрийн харъяанд буй хүн амыг ч гэсэн энэ талаар нөлөөлөн, урианхай нарыг нэгтгэж авах бодлоос татгалзахгүй байгаа хүрээний тусгай элч нарыг угтан авсан бололтой" хэмээн мэдээлжээ. И.Я.Коростовец С.Д.Сазановт "Гомбодоржийн засаглалыг янз бүрийн арга замаар бэхжүүлнэ гэж амлан" түүнийг Орос руу татахыг зөвлөсөн байна.⁶⁸

1913 оны 11-р сарын 5-нд гарын үсэг зурсан монголын асуудлаархи Орос-хятадын тунхаглал нь урианхай нарын Халхтай нэгдэх гэсэн итгэл найдварт цохилт болсон юм. Энэ тунхаглалаар Халх болон баруун Монголыг Гадаад Монголын бүрэлдхүүнд оруулж, Өвөр Монгол, Барга мөн Урианхайн хязгаарыг хаант Орос Гадаад Монголын гадна орхигдуулсан.

Гэвч хүрээний засгийн газар Урианхайг алдахыг хүсэхгүй байлаа. Тэд урьдын адил өөрийн түшмэдүүдийг тэндээс алба тугуулахаар илгээсээр байв. Урианхайн сайн дурын цэргийн отряд монгол цэргийн бүрэлдхүүнд Ховдод байрласаар байв. Оросын дипломат төлөөлөгч, Монгол дахь ерөнхий консул А.Миллер монголын засгийн газраас Урианхайн хязгаар руу "монгол элч нар" илгээхээ зогсоож, Ховдод монголын цэрэгт алба хааж буй урианхай нарыг халж явуулахыг удаа дараа шаардаж байв.⁶⁹ Хүрээний удирлага А.Миллерийн сануулгыг нэг их анхаараагүйгээр барахгүй 1914 оны хавар Жалханз хутагтыг Урианхайн хязгаарын захирагчаар томилжээ.⁷⁰ А.Церерин монгол түшмэдийг Урианхайгаас хүчээр хөөж монголчуудыг доромжилжээ. Монголын ГЯЯ үүний төлөө А.Цереринийг хариуцлагад татахыг А.Миллерээс шаардав.⁷¹ Харин А.Миллер монголчуудад: "Монголын засаг захиргаа Монголтой ямар ч холбоогүй, түүнд хяръяалагддаггүй хүн амын эрх ашиг, хүмүүсийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцоор байгаад маш их гайхал төрж буйгаа дахин хэлэхээс аргагүй. Засагт хан болон Сайн ноён хан аймгийн дарга нар, мөн Жалханз хутагтад Урианхайн хязгаар нь Орос, Хятадын маргаантай нутаг бөгөөд Монголын бүрэлдхүүнд ордоггүй гэдгийг өнөөг хүртэл мэдэгдээгүй бололтой"⁷² хэмээн хариулжээ.

Монголын засгийн газар урианхайн асуудлыг Хиагтын орос-хятад-монгол гурван улсын хэлэлцээрт оруулахаар бэлтгэж байв. Энэ зорилгоор 1914 оны зун урианхайн ноёдыг "архивын бичиг баримтын хамт" Хүрээнд ирүүлэхээр дуудсан.⁷³ Гэвч хаант засгийн газар урианхайн асуудлыг Хиагтын бага хурлаас өмнө нэгэнт шийдвэрлэчихсэн юм.

А. Церерин болон хаант оросын бусад түшмэд монголчуудыг Урианхайгаас хөөн явуулаад зогсохгүй нутгийн дээдсийн дунд тодорхой явууллага хийсээр байв. А.Церерин урианхайн хошуудаар байнга явж хошуу ноёдын итгэлийг олж авахын тулд тэдэнтэй удтал ярилцаж байлаа.⁷⁴ Урианхайд Эрхүүгийн захирагч М.С.Князев ч очсон. Тэрбээр Да, Бэйс хошуудын төлөөлөгчидтэй уулзан "Урианхайн газар нутгийг эзэмших гэсэн монголын санаархал ямар ч үндэслэлгүй" гэдгийг тэмдэглэж байв.⁷⁵ А. Церерин урианхай нарыг "оросын засгийн газарт хандан ивээлд орох юм

уу, харъяат болох хүсэлт гаргахыг" ятгав.⁷⁶ Ялангуяа хамгийн нөлөө бүхий хоёр том хошуу болох Да, Бэйс хошууны ноёдод их анхаарал хандуулсан. Тэд ч монголтой нэгдэх зам нь таслагдсан гэдгээ ойлгосон, харин өөрсдөө Хятадтай нийлэхийг хүсээгүй. Хоёр том гүрний дунд хавчигдсан Урианхайн жижиг ард түмэн өөрийн тусгаар тогтнолоо хадгалж чадахгүй тул тэдэнд Оросын ивээлд орох ганцхан зам үлдсэн юм.

1914 оны 1-р сард Да, Бэйс хошуудын ноёд А.Цереринээр дамжуулан М.С.Князевт Орос улсын ивээлд орох хүсэлтээ тавив. Оросын хаанд бичгээр илгээсэн хүрсэлтэндээ тэд оросын засгийн газар ламын шашин шүтэх, нүүдлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрч, цэргийн албанд татахгүй байхыг хүсчээ.⁷⁷

М.С.Князев Да, Бэйс хошуу ноёдын, мөн түүнчлэн амбан ноён Гомбодоржийн хүсэлтийг Петербург руу Николай II хаанд дамжуулахын хамт илгээсэн захидалдаа "урианхай нарын дээр дурьдсан хүсэлтэнд хэрэв албан ёсоор оросын ивээлд авахгүй бол ядахдаа тэднийг өөрийн ивээлд оруулснаа албан ёсоор зарлах хэлбэрээр тодорхой хариу өгөхийг хүсээд", оросын засгийн газар уг хүсэлтийг хүлээж авахаас татгалзвал "тэд өөрийн шашны толгой Хүрээний хутагтаас өмгөөлөл эрэхэд хүрэх болно" гэдгийг цохон дурьдсан байлаа.⁷⁸

С.Д.Сазанов урианхай нарын хүсэлт гаргасан асуудлыг шийдвэрлэхийн тулд Сайд нарын зөвлөлийн дарга И.Л.Горемыкин, Цэргийн сайд В.А.Сухомлинов, Дотоод явдлын сайд Н.А.Маклаков болон газар зохион байгуулалт, газар тариалангийн газрын орлогч дарга П.Н.Игнатъев нарт захидал илгээжээ. Гадаад явдлын сайд захидалдаа урианхай нарыг Оросын ивээлд авах үзэл бодлоо илэрхийлж бичихдээ Орос орон Урианхайн хязгаарыг оросын нутаг гэж зарлахуйц хүчтэй биш байгаа тул урианхайн асуудалд "болгоомжтой, дэс дараатай хөдлөх" хэрэгтэй. Иймээс урианхай нарыг Оросын ивээлд авах тухай М.С.Князевийн саналыг хүлээж авууштай. Цааш нь сайд "оросын ивээлд авах зөвшөөрөл өгөхдөө бид тэд нараас тодорхой үүрэг амлалт авах хэрэгтэй", тухайлбал тэдний гадаадтай харилцах эрхийг хасах, орос иргэд тэдний хоорондын маргааныг зөвхөн А.Церериний зуучлалаар шийдвэрлэх хэрэгтэй хэмээн дурьджээ.⁷⁹

В.А.Сухомлинов С.Д.Сазановт түүний санал бодлыг дэмжээд, "одоогоор урианхай нарыг оросын харъяатаар бус зөвхөн оросын ивгээлд оруулах явдлаар хязгаарлах хэрэгтэй" гэж бичжээ. Цэргийн сайд цааш нь бичихдээ "харин иймэрхүү байдлаар Урианхайн хязгаарт манай нөлөөг тогтоох нь зайлшгүй бөгөөд энэ бол миний бодлоор тус хязгаарыг эзэнт гүрэнд бүрэн нэгтгэх эхний алхам болох юм" гэсэн байна.⁸⁰ Н.Маклаков "урианхай нарыг Орос улс ивээлдээ авах явдлаар одоохондоо хязгаарлах хэрэгтэй" хэмээн үзэв. П.Н.Игнатъев "Урианхайн бүх хүн амыг газар усных нь хамт их Орос гүрний бүрэлдхүүнд шууд харъяат болгон авах" асуудлыг хаанд нэн даруй" тавих хэрэгтэй гэсэн саналтай байлаа.⁸¹

С.Д.Сазанов И.Л.Горемыкинд бичсэн захидалдаа П.Н.Игнатьевын бодол дүгнэлттэй санал нийлэхгүй байгаагаа илэрхийлжээ. Тэрбээр 1911 оны 11-р сарын 21-ны Сайд нарын зөвлөлийн Онцгой зөвлөлгөөн Урианхайн хязгаарыг Орост нэгтгэх "хууль зүйн үндэслэл" олоогүй болохыг тэмдэглэжээ. Сайд цааш нь бичихдээ "тэдний /урианхай нарын/ нутаг усыг нэгтгэх, шаардлагагүй, тэгээд ч урианхайн асуудал дээр манай барьж буй чиг зорилго Хятад болон Монголтой харилцах харьцаанд ээдрээ төвөгтэй асуудлууд үүсгэж мэдэх эрс арга хэмжээнээс зайлсхийхэд хүргэж байна" гэжээ.⁸²

Гэхдээ С.Д.Сазанов хэрэв Хятад цэргээ оруулахыг оролдвол Урианхайн хязгаар руу явуулах цэргийн отряд бэлтгэхийг В.А.Сухомлиновоос хүсчээ. В.А.Сухомлинов ГЯЯ-ны сайдад өгсөн хариундаа, хятадын цэрэг Урианхай руу очихын тулд зөвхөн Алтайн Тойргоос Гадаад Монголын Ховдын хэсгээр дайран өнгөрөх бөгөөд тэнд хангалттай хүчтэй сайн зэвсэглэсэн/ их буу, пуёмёттой/ орос цэргийн отряд байрлаж байгаа гэжээ.⁸³

4-р сарын 17-нд Николай II хаан "Урианхайн таван хошууны хүн амыг" /А.Цереринээр дамжуулан/ "Оросын засгийн газрын ивгээлд авах тухай мэдэгдэлд "зөвшөөрөл" өгчээ. Уг ивээлд орсноор урианхай нар "оросын засгийн газрыг тус нутагт төлөөлсөн этгээдийн зуучлалгүй гадаад орны засгийн газартай аливаа харилцаа тогтоохгүй байх" үүрэг хүлээжээ.⁸⁴ 7-р сарын 17-нд А.Церерин Булаг тосгонд амбан ноён Гомбодорж болон Да, Бэйс хошуудын ноёдод тэднийг Оросын ивээлд авсан тухай зарлан мэдэгдэв.⁸⁵ Гомбодорж үүнээс хойш "Монгол болон бусад оронтой бие даан шууд харилцаа тогтоохгүй" гэсэн амлалтыг бичгээр үйлдэн А.Цереринд гардуулжээ. Амбан ноён урианхай нараас "ёс заншил, буддын шашин, амьдралын хэв заншил, өөрөө удирдах ёс, зэрэг дэв болон төрөлх нутгаа" орхихыг хүссэн байна.⁸⁶

7-р сарын 17-нд Николай II хааны зарлигийг сонордуулах ёслол болсон Булаг тосгонд тэр үед цагаан хааны ивээлд орохоос татгалзаж байсан Салчиг, Тож хошууны ноёд ирээгүй. А.Церериний явуулсан "орос хүмүүстэй" ч уулзахаас зайлсхийж байлаа.⁸⁷

А.Церерин хааны зарлигийг сонордуулахдаа Гомбодоржид Орос улс түүний харъяанд байгаа Ойнар, Салчиг, Тож хошуудыг ивээлдээ авсан тухай мэдэгдэв. Урианхайн хязгаарын хэргийг эрхэлсэн комиссар А. Церериний тэр үед хашиж байсан албан тушаалын албан ёсны нэр Гомбодоржоос Салчиг, Тож хошууд дахь өөрийн "хууль ёсны эрх мэдлээ" сэргээхийг хүссэн.⁸⁸ Тэрбээр дараа нь А.Церерин болон бусад орос түшмэдийн туслалцаатай энэ хоёр хошууны ардуудыг Орос улсын өмгөөлөл, ивээлд оруулж чадсан юм.

1914 оны намар Гадаад Монголын хувь заяаг тодорхойлох асуудлаар орос-хятад-монгол гурван улсын хэлэлцээр Хиагт хотноо нээгдсэн билээ. Гурван улсын энэ бага хурлын өмнө хаант засгийн газар Хүрээний засгийн

газарт хандаж хурал дээр урианхайн асуудлыг сөхөж тавихгүй байхыг хатуу анхааруулжээ. Монголчууд ч гэсэн үүнийг дагасан юм. Харин хятадын төлөөлөгчид бага хурал дээр Урианхайн тухай асуудлыг гаргаж тавихыг оролдсон боловч Оросын талыг толгойлсон А.Миллер энэ саналыг няцаав. Хиагтын хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа /1915 оны 6-р сарын 7/ Гадаад Монголын засгийн газар өөрийн эрх хэмжээг зөвхөн Халх, Ховдын тойргоор хязгаарласан хэлэлцээнд гарын үсэг зурсан учир Урианхайн хязгаарыг өөртөө нэгтгэх оролдлого хийгээгүй. Энэ баримт бичигт Хятад улс гарын үсэг зурснаар мөн Оростой хийх хэлэлцээрт урианхайн асуудлыг сөхөн тавих хууль зүйн үндэслэлгүй болсон юм.

Ишлэл, зүүлт

1. Кабо Р.М.Очерки истории и экономики Тувы, ч.1 М.-Л., 1934
2. Дулов В.И.Социально-экономическая история Тувы (XIX-начало XX вв.), М., 1956
3. Шаэцинкюэ жунгуо сибэй бянзьяни (хаант Орос Хятадын баруун хойд нутагт түрэмгийлсэн түүх) Бээжин., 1979, х. 379, 387; ФуСуньмин болон бусад. Шаэ Цинь хуа и зяньбянь (Хаант Орос Хятадад түрэмгийлсэн түүхэн найруулал), Чанчунь, 1982, х. 402; 407.
4. Шаэ Цинь хуа и (Хаант Орос Хятадад түрэмгийлсэн түүх), Шанхай, 1986, х. 485-489.
5. Оросын ГЯЯ-наас бэлтгэсэн лавлах. 1911. -Оросын гадаад бодлогын архив /ОГБА/. Фонд-Кинтайский стол, хавтаст хэрэг /хх/-761, хуудас- 300; Очерк Урянхайского края. Эрхүүгийн цэргийн тойргийн штабын Тагнуулын хэлтэс бэлтгэв. 1912 оны 2-р сар.- "Сведения о государствах Дальнего Востока", Эрхүү 1912, № 2, х. 15
6. ОГБА. Ф.Китайский стол, хх. 3110, х.200
7. Особый журнал Совета Министров. 1911 оны 11-р сарын 21.-Мөн тэнд ХХ. 761, х.310
8. "Сведения о государствах Дальнего Востока", 1912, № 2, х.15
9. Эрхүүгийн захирагч М.С.Князеваас ГЯЯ-ны сайд С.Д.Сазановт 1914 оны 2-р сарын 6-нд бичсэн захидал. -ОГБА. Ф.Китайский стол, ХХ. 3113, х.11
10. Особый журнал Совета Министров. 1911 оны 11-р сарын 21.-Мөн тэнд ХХ. 761, х.310, 316
11. Справка об Урянхайском крае. 1912 оны эцсээр Сайд нарын зөвлөлийн тамгийн газраас бэлтгэв. -С.-Петербург дахь Улсын түүхийн төв архив /ПУТТА, Ф.565, хх. 19655, х. 116; ОГБА. Ф.Китайский стол, ХХ.3111, х. 191.
12. Г.Е.Грум-Гржимайло. Западная Монголия и Урянхайский край, т.3, вып.2, Л., 1931, х.540.
13. В.Л.Попов. Второе Путешествие в Монголию. Эрхүү, 1910, х.12

14. Эрхүүгийн захирагч М.С.Князевийн Усинскийн тойрог болон хил залгаа Урианхайн хязгаарын асуудлаар хийсэн нууц тэмдэглэл. 1913 он ОГБА. Ф.Китайский стол, Хх. 3109, х. 145 /Хэнд зориулсан нь тодорхойгүй/
15. Мөн тэнд, х.145 16. Р.М.Кабо, Дурьдсан зохиол., х.113
17. ОГБА. Ф.Китайский стол, Хх. 3110, х.64 Усинскийн тойрог Енисей губерний Минусинск уездын бүрэлдэхүүнд багтаж, Урианхайн хязгаартай хиллэж байв.
18. Селивановаас Сайд нарын зөвлөлийн дарга П.А.Столыпинд 1909 оны 2-р сарын 12-нд бичсэн захидал. -мөн тэнд Х.99-100
19. В.Долбежевоос Оросын ГЯЯ-ны 1-р газарт 1909 оны 1-р сарын 12-нд явуулсан мэдээлэл. -мөн тэнд, х.65
20. В.Л.Попов -Эрхүүгийн захирагч Селивановын тамгын газрын дарга, 1909 оноос Эрхүүд байрлаж байсан Сибирийн буудлагын 7-р дивизийн штабын дарга болсон. Орос иргэдийг урианхай нарын халдлагаас сэргийлэх зорилгоор 1903, 1909 онуудад Урианхайд "экспедицүүд" зохион байгуулсан. Тогтмол хэвлэлд урианхайн асуудлаар материал хэвлэлүүлж байсан. Урианхайн асуудлыг шийдвэрлэхэд Эрхүүгийн захирагч М.С.Князев болон Эрхүүгийн цэргийн тойргийн штабын генералуудад нөлөө бүхий байв. /ОГБА. Ф.Китайский стол, Хх. 3111, х.73-75/. Попов Урианхай дахь орос Хятадын хил нь Тагнын нуруугаар байх ёстой гэж үздэг. Хилийн талаархи өөрийн үзэл баримтлалаа тэр гол төлөв Урианхайн хязгаар XV11 зуунд Оросын харъяанд байсан болон Хятадын хилийн харуулууд Саяаны нуруунд бус Тагнын нурууны өмнө бэлээр байсан гэдэгт үндэслэжээ. /В.Л.Поповоос урианхайн асуудлаар Бээжинд сууж байсан Оросын Элчинтэй харилцсан захидлууд, 1909 он. - ОГБА Ф.Миссия в Пекине, ХХ.460, х.35-46/.
21. Иш татсан: Р.М.Кабо, дурьдсан зохиол., х.151
22. ОГБА. Ф.Китайский стол, Хх. 3110, х.202
23. И.Я.Коростовецоос С.Д.Сазановт 1911 оны 3-р сарын 16-нд явуулсан нууц цахилгаан, - мөн тэнд, Ф.Канцелярия министра, Хх. 107, х.231
24. Иш татсан: В.И.Дулов, Дурьдсан зохиол., х.383.
25. И.Я.Коростовецоос А.П.Извольскийд 1909 оны 4-р сарын 4-нд явуулсан нууц мэдээлэл. -ОГБА. Ф.Китайский стол, хх. 3110, х.203
26. И.Я.Коростовецоос С.Д.Сазановт 1910 оны 10-р сарын 19-нд явуулсан нууц цахилгаан. -Мөн тэнд, Ф.Канцелярия министра, Хх.460, х.78
27. ОГБА Ф.Китайский стол, ХХ. 133, х.137, 164, 389.
28. И.Я. Коростовецоос С.Д.Сазановт 1910 оны 4-р сарын 10-нд явуулсан нууц мэдээлэл-Мөн тэнд, х. 162, 164.
- 28а. 1864 оны Чугучакийн Протокол нь 1727 оны Буурын болон Хиагтын гэрээгээр тогтоосон орос-Хятадын хилийг нотолсон. Энэ Протоколын дагуу 1869 онд орос, хятадын комиссарууд Саяаны нуруугаар хилийн тэмдэгтүүд байрлуулсан.

29. ОГБА. Ф.Миссия в Пекине, ХХ.460, х.159.
30. Мөн тэнд, Ф.Канцелярия министра, хх. 107, х338
- 31."Жунгуо бао", 2.II.1911.-мөн тэнд, Ф.Миссия в Пекине, хх. 107, х.138-139.
32. И.Я.Коростовецоос Цин ноёнд 1911 оны 9-р сарын 11-нд явуулсан захидлын хуулбар. - Мөн тэнд, х.11
33. Цин ноёноос Бээжин дэх оросын элчинд 1911 оны 9-р сарын 11-нд явуулсан захидлын хуулбар. -мөн тэнд, х.11
34. И.Я.Коростовецоос А.А.Нератовт 1911 оны 9-р сарын 19-нд явуулан нууц цахилгаан.- мөн тэнд. Ф.Китайский стол, хх. 135, х. 101.
35. М.С.Князеваас Сайд нарын зөвлөлд 1911 оны 9-р сарын 21-нд явуулсан нууц захидал., -мөн тэнд, х. 138.
36. И.Я.Коростовецоос А.А.Нератовт 1911 оны 10-р сарын 3-нд явуулсан нууц цахилгаан. - мөн тэнд, Х.137.
37. Гүн С.Л.Владиславович-Рагузинский 1727 онд Хиагтын гэрээнд гарын үсэг зурсан.

"Восток" сэтгүүлийн 1995 оны №1-ээс орчуулсан Д.Шүрхүү

**Зүүн Хойд Азийн Байгалийн хийн
хоолойн тухай**

Доктор Ц.БАТБАЯР

1. Хүйтэн дайны дараа үеийн Зүүн Хойт Ази

"Хүйтэн дайн" төгсгөл болсноор дэлхий нийтийг хамарсан хоёр эвсэл, хоёр системийн хооронд дайн гарах аюул үгүй боллоо. ЗХУ задарснаар Евразийн газрын зурагт зарчмын өөрчлөлт гарч шинээр тусгаар тогтносон 15 улс хуучин Зөвлөлтийн буурин дээр өрх гэрээ засаж байна.

АНУ, Орос хоёр харилцан дайсагналцахаа больж том хэмжээний мөргөлдөөн гарах үүд хаагдлаа. Орос, Хятадын хилийн дагуу цэргийн сөргөлдөөн арилж харилцан итгэлцэх хэлбэрт шилжиж байна.

Гэвч Ази "хүйтэн дайны" өвөөс бүрэн ангижирсан гэж хэлэхэд учир дутгадалтай. "Хүйтэн дайны" Ази дахь гол бүтээгдэхүүн болох Солонгосын хойгийн хуваагдмал байдал хэвээр байна. Орос-Японы хооронд газар нутгийн асуудал шийдэгдээгүй хэвээр, өнөөг хүртэл энхийн гэрээ алга байна. БНХАУ-Тайваны хооронд ч хэрхэн нэгдэх талаар зарчмын зөрчил гүнзгийрсээр байна. Түүн дээр Орост улс төрийн байдал ужиг тогтворгүй хэвээр байна.

а/Орос-Хятадын харилцаа 1990-ээд онд маш эрчимтэй хөгжих замдаа